



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/151

Улаанбаатар хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.6 дахь заалт, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын баяр наадам, Ардын хувьсгалын 104 жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл гарган ажиллаж, дүүрэг, орон нутгийг хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж буй иргэдийг Засаг даргын “Жуух бичиг”, мөнгөн шагналаар шагнасугай.

2. Засаг даргын шагналаар шагнагдах иргэдийн нэрсийг нэгдүгээр, зарцуулах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шагналд зарцуулах 420,000 (дөрвөн зуун хорин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД